

Өлгий сумын ЗДТГ-ын 7 хоногт хийсэн ажлын мэдээлэл

- 4-р сард тамхи худалдах улсын тэмдэгтийн хураамж төлсөн нийт 9 хүнсний дэлгүүрт тусгай зөвшөөрөл олгосон Засаг даргын захирамжийг гаргаж, хурамжийг орон нутгийн татварын дансанд төвөрүүлэв.
- 1/36 орон сууцны дээвэр салхинд хийссэн тул газар дээр нь очиж нөхцөл байдалтай танилцан зураг авч баримтжуулав.
- Захиргааны хэрэг зөрчлийн улмаас хураагдсан зүйлсэд үнэ тогтоож худалдан борлуулах ажлын комиссийн бүрэлдхүүнийг шинэчлэн тогтоосон болно.
- Хот доторхи хар замын эвдэрсэн хэсгийн нөхөөс засварын хэмжээг тогтоов.
- Хотын төвд авто замын тэмдэг, тэмдэглэгээ тавих ажлын тоо хэмжээг шинэчилэн гаргаж, төсөвт шилжүүлэв.
- Сумын Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрийн 2017 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг боловсруулав.
- 9 байгууллагад орчиноо тохижуулах хашаа байшинг засварлах талаар зөвлөмж хүргэж ажиллав.
- Стадионы засварын ажлын хэмжээг гаргаж төсөвт шилжүүлэв.
- Аймгийн онцгой байдлын газраас зохион байгуулсан сургууль семинарт оролцов.
- Сум хөгжүүлэх сангийн зээлдэгч нартай утсаар холбоо тогтоов. Орон нутгийн мэдээлэлийн хэрэгсэлээр зээлдэгч нарт урьдчилан анхааруулах мэдээлэл өгөв. Энэ 7 хоногт 3 зээлдэгч зээлээ бүрэн төлөв.
- Өлгий сумын хэмжээний мал хорогдолт, төл бойжуулалтын мэдээг гаргаж аймгийн ХХАХГ-т хүргүүлэв.
- Аймгийн төвийн “Каз тэжээл” малын захын эзэнтэй уулзаж малын захад малын эмч ажиллуулах тухай сумын Засаг даргын албан бичгийг хүргүүлж, малын захад хяналтын ажил зохион байгуулав.
- Өлгий сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ахуй үйлчилгээний нэгжүүдийн мэдээллийг нэгтгэж гаргав.
- Аймгийн ЗДТГ-ын ХШҮТ-с зохион байгуулах Хяналт шинжилгээний ажлын бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.
- Гудамж зам талбайн цэвэрлэгээ хийж 4 тн хог ачиж хогийн цэгт хүргэв.
- 11-4-р багийн гэрэлтүүлгийг засварлан хийж дуусгав.
- Ногоон бүсийн хашаануудыг услах ажил хийж байна.
- Захиалгаар явж 4ш нохой буудаж устгалд оруулав.
- Гудамжинд мод суулгах нүх ухаж байна.